



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУГАТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БУА-2023/132/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>БУЛГАН ХОТ</p> <p>2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас:70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Содном Утас:70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.06 № 20

танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Ш.МОНГОЛЖИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 6 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг төлөвлөн ажиллаж 92.3 хувийн биелэлттэй тайлагнасан, батлагдсан төсвийн 92.1 хувийг гүйцэтгэлээр зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс 65,412.3, орон нутгийн төсвөөс 22,018.8, үндсэн үйл ажиллагааны орлогоос 800.0, туслах үйл ажиллагааны орлогоос 600.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагааны орлогыг 2,750.0 мянган төгрөгөөр тасалсан, 2022 онд авлагын эхний үлдэгдэл 817.6 мянган төгрөгөөс 600.0 мянган төгрөгийг барагдуулж, НДШ-ийн 1274.9 мянган төгрөгийн авлага нэмэгдэж 1492.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 664.7 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна.

Бугат сумын Соёлын төвийн 2022 санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

006020022

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,676,133.40</u>	<u>22,127,509.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,089,436.60
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,089,436.60
3121	Төгрөг	-	1,089,436.60
31211	Төрийн сангийн харилцах	-	1,089,436.60
33	АВЛАГА	817,591.40	1,492,530.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	817,591.40	1,492,530.40
35	БАРАА МАТЕРИАЛ	15,858,542.00	19,545,542.00
354	Хангамжийн материал	15,858,542.00	19,545,542.00
35420	Аж ахуйн материал	15,858,542.00	19,545,542.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,911,856.25</u>	<u>50,490,847.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,911,856.25	50,490,847.43
392	Биет хөрөнгө	24,089,856.25	46,168,847.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,052,740.00	21,052,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,052,740.00)	(21,052,740.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,515,676.70	34,634,305.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,013,711.71)	(5,870,389.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,154,272.30	13,270,402.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,906,050.03)	(10,005,027.07)
39214	Бусад үндсэн хөрөнгө	292,896.36	292,896.36
39215	Хуримтлагдсан элэгдэл	(256,284.21)	(292,896.36)
39217	Ном	13,303,056.84	14,139,556.84
393	Биет бус хөрөнгө	2,822,000.00	4,322,000.00
39301	Програм хангамж	50,000.00	1,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(50,000.00)	(50,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,822,000.00	2,822,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>43,587,989.65</u>	<u>72,618,356.43</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>664,747.12</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	664,747.12
413	Өглөг	-	664,747.12
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	664,747.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>43,587,989.65</u>	<u>71,953,609.31</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	43,587,989.65	71,953,609.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	48,100,253.54	48,100,253.54
51101	Өмч: - төрийн	48,100,253.54	48,100,253.54
512	Хуримтлагдсан үр дүн	(60,600,799.59)	(32,235,179.93)
51210	Өмнөх үеийн үр дүн	(60,600,799.59)	(60,637,411.62)
51220	Тайлант үеийн үр дүн	-	28,402,231.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,088,535.70	56,088,535.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>43,587,989.65</u>	<u>72,618,356.43</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	110,182,000.00	111,829,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	24,398,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	24,398,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	24,398,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	800,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	23,598,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	110,182,000.00	87,431,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	65,412,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	65,412,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,182,000.00	22,018,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,182,000.00	22,018,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	108,112,477.19	83,426,868.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,112,477.19	83,426,868.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,091,051.66	80,275,442.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,523,457.04	49,763,487.29
210101	Үндсэн цалин	34,400,793.04	46,326,775.12
210102	Нэмэгдэл	9,122,664.00	2,043,038.45
210104	Урамшуулал	-	1,393,673.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,370,166.32	4,608,502.23
210201	Тэтгэврийн даатгал	3,695,203.10	2,946,953.52
210202	Тэтгэмжийн даатгал	427,327.66	341,944.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	330,261.54	266,076.56
210204	Ажилгүйдлийн даатгал	91,720.50	87,232.47
210205	Эрүүл мэндийн даатгал	825,653.52	966,295.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,445,772.25	17,498,656.55
210301	Гэрэл, цахилгаан	296,332.25	439,216.55
210302	Түлш, халаалт	17,149,440.00	17,059,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,827,600.00	678,000.00
210401	Бичиг хэрэг	366,500.00	55,000.00
210402	Тээвэр, шатахуун	152,500.00	458,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	505,900.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	727,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	80,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	80,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	56,000.00
210702	Дотоод албан томилолт	-	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,347,100.00	4,696,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	347,100.00	4,696,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,576,956.05	2,894,796.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	58,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,576,956.05	2,836,796.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,021,425.53	3,151,425.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,991,000.00	768,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,791,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	768,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,425.53	2,383,425.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,425.53	2,383,425.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,069,522.81</u>	<u>28,402,231.69</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,069,522.81</u>	<u>28,402,231.69</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>110,182,000.00</u>	<u>88,831,100.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	<u>1,400,000.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,400,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,400,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>110,182,000.00</u>	<u>87,431,100.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	65,412,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	65,412,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,182,000.00	22,018,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,182,000.00	22,018,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>110,182,000.00</u>	<u>84,887,263.40</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>110,182,000.00</u>	<u>84,887,263.40</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>74,160,574.47</u>	<u>81,735,837.95</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,523,457.04	49,098,740.17
210101	Үндсэн цалин	34,400,793.04	45,904,674.30
210102	Нэмэгдэл	9,122,664.00	1,800,392.15
210104	Урамшуулал	-	1,393,673.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,250,205.18	5,883,441.23
210201	Тэтгэврийн даатгал	3,575,241.96	4,087,653.52
210202	Тэтгэмжийн даатгал	427,327.66	476,183.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	330,261.54	266,076.56
210204	Ажилгүйдлийн даатгал	91,720.50	87,232.47
210205	Эрүүл мэндийн даатгал	825,653.52	966,295.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,927,712.25	17,498,656.55
210301	Гэрэл, цахилгаан	296,332.25	439,216.55
210302	Түлш, халаалт	21,631,380.00	17,059,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	321,500.00	319,000.00
210401	Бичиг хэрэг	56,500.00	55,000.00

210402	Тээвэр, шатахуун	100,000.00	99,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	361,000.00	1,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	65,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	296,000.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	56,000.00
210702	Дотоод албан томилолт	-	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,776,700.00	6,336,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,776,700.00	6,336,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,144,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,144,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,021,425.53	3,151,425.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,991,000.00	768,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,791,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	768,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,425.53	2,383,425.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,425.53	2,383,425.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	3,943,836.60
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,854,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,854,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,854,400.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,854,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(2,854,400.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,089,436.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,089,436.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(62,670,322.40)	41,518,466.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(62,670,322.40)	41,518,466.84
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,069,522.81	2,069,522.81
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(60,600,799.59)	43,587,989.65
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(60,600,799.59)	43,587,989.65

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(36,612.03)	(36,612.03)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(60,637,411.62)	43,551,377.62
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	28,402,231.69	28,402,231.69
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,100,253.54	56,088,535.70	(32,235,179.93)	71,953,609.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,581,100.00	85358227.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,581,100.00	85358227.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,813,100.00	84590227.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,098,800.00	49098740.17
210101	Үндсэн цалин	45,253,900.00	45904674.30
210102	Нэмэгдэл	3,844,900.00	1800392.15
210104	Урамшуулал		1393673.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,039,300.00	5883431.23
210201	Тэтгэврийн даатгал	4,106,700.00	4087653.52
210202	Тэтгэмжийн даатгал	483,100.00	476173.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	386,500.00	266076.56
210204	Ажилгүйдлийн даатгал	96,700.00	87232.47
210205	Эрүүл мэндийн даатгал	966,300.00	966295.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,882,000.00	17498656.55
210301	Гэрэл, цахилгаан	400,000.00	439216.55
210302	Түлш, халаалт	19,482,000.00	17059440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	825,000.00	817500.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	55000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	99000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	498,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,400,000.00	1,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,860,000.00	7,836,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,860,000.00	7,836,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,650,000.00	1,999,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,650,000.00	1,999,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,000.00	768,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	768,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91,581,100.00	88,831,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,412,300.00	65,412,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	65,412,300.00	65,412,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,018,800.00	22,018,800.00

132001	Орон нутгийн төсвөөс	22,018,800.00	22,018,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,150,000.00	1,400,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,650,000.00	800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	600,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,089,436.60
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5.00	5.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00
620004	Гэрээт ажилтан		

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган аймгийн Бугат сумын Соёлын төв нь ард иргэдэд соёл урлаг, олон нийтийн арга хэмжээг зөв боловсон хүргэж, хүүхэд залуучуудын авьяас билгийг нээн илрүүлж, олныг хүртээл болгох мөн соёлын үйлчилгээний цар хүрээг өргөтгөж соёлын стандартын шаардлагыг хангах зорилготой соёл урлагийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тус байгууллага нь 2022 онд үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахаар дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

- ❖ Соёл урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор бэлтгэн, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах,
- ❖ Үндэсний уламжлал, өв соёлыг дэлгэрүүлж, орон нутаг судлах танхимын сан хөмрөгийг нэмэгдүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалын зүйлсийг хамгаалах,
- ❖ Соёлын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шат дараатай нэмэгдүүлэх,
- ❖ Иргэд хүүхэд залуучуудад соёлын үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэн, дугуйлан секцийг хичээллүүлэх,
- ❖ Номын сангийн орчин нөхцөл үйлчилгээг сайжруулах, номын сангийн бүртгэл хөтлөлт, номын фонд баяжилтыг нэмэгдүүлэх,
- ❖ Анхдагч түмний бахархал, монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, орчин үеийн соёл, урлагийг түгээн дэлгэрүүлэх зэрэг 6 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж 91.3 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Бугат сумын Соёлын төв нь Булган аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/124 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтсээс тус онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29030.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		1089.4	1089.4
Авлага	817.6	1492.5	674.9
Бараа материал	15858.5	19,545.50	3687
Үндсэн хөрөнгө	26,911.80	50,490.80	23579
Нийт хөрөнгө	43,587.90	72,618.20	29,030.30
Өр төлбөр		664.7	664.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	43,588.00	71,953.60	28365.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	43,588.00	72,618.30	29,030.30

Дээрх хүснэгтээс харахад төрийн сангийн харилцах данс нь дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1089.4 мянган төгрөг нь улсын төсвийн санхүүжилтээс зарцуулаагүй үлдсэн байна.

Авлага: Авлага дансны оны эхний үлдэгдэл 817.6, оны эцэст 1492.5 мянган төгрөг болж өмнөх оноос 674.9 мянган төгрөгөөр өссөн байна. Авлагын эцсийн үлдэгдлийн 1492.5 мянган төгрөг нь нийгмийн даатгалаас авах авлага ба тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 15858.5, эцсийн үлдэгдэл 19545.5 мянган төгрөг болж өмнөх оноос 3687.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5704.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 2017.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж, үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталж устгасан материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 83,190.6, оны эцсийн үлдэгдэл 87,761.9 мянган төгрөг болж өмнөх оноос 4,571.3 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,854.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, аймгийн Соёлын газраас 18085.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлснийг орлогоор бүртгэсэн байна. Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 13,806.9 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж шинээр үнэ тогтоон 5,175.0 мянган төгрөгөөр орлогод авч, 8074.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр: Тайлант онд шинээр цалингийн 664.7 мянган төгрөгийн өглөг үүсэж аймгийн татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 65412.3, орон нутгийн төсвөөс 22018.8, үйл ажиллагааны орлогоос 3650.0 мянга нийт зарлагыг 91081.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 65412.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 22018.8, үйл ажиллагааны орлогоос 3650.0, туслах үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 65412.3, орон нутгийн төсвөөс 22018.8, үндсэн үйл ажиллагааны орлогоос 800.0, туслах үйл ажиллагааны орлогоос 600.0 мянган төгрөгийн орлого, санхүүжилт авч үйл ажиллагааны орлогыг 2750.0 мянган төгрөгөөр тасалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 85358.2 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг тогтмол зардлыг 2383.3, бараа үйлчилгээний зардлыг 3650.1 төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

X201 хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагаа	61644.3	61456.4	187.9	
2	80214 уран бүтээл хийх зардал	3000.0	3000.0	0	
3	80802 АО олгос тэтгэмж	768.0	768.0	0	
4	83603 нэмэлт	800.0	498.5		
5	80111 тогтмол	20182.0	17798.7		
6	80112 нийтлэг үйлчилгээ	1836.8	1836.7		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт байхгүй

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын туслах үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 91,581.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,831.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага үйл ажиллагаандаа, санхүүгийн тайланд горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ.

Үүнд: Бараа үйлчилгээний зардлаас хүндэтгэл үзүүлэх гэх утгатай бэлэг дурсгалын зүйлд 200.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96

мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1441.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч хэрэгжилтийн тооцон хариуг 2022 оны 03 дугаар сарын 15 тоот албан бичгээр хариу ирүүлж, бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	1441.1	2	1441.1	100
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1274.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1274.9 мянган төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Үүнд: Тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн 1274.9 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 16700.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 200.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 16,500.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Бараа үйлчилгээний зардлаас хүндэтгэл үзүүлэх гэх утгатай бэлэг дурсгалын зүйлд 200000 төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

1. Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс ажлаас чөлөөлөгдсөн Соёлын төвийн эрхлэгч И.Пүрэвбатад ажилгүй байсан хугацааны цалин 14,694,939 төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас төлсөн ч буруутай албан тушаалтнаар байгууллагын хохирлыг барагдуулаагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Бараа үйлчилгээний зардлаас 1505900, бусдаар гүйцэтгүүлэх зардлаас 300000 төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, чанар хүртээмж, өмч хөрөнгөтэй холбоотой дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй нь ЗГ-ын 2011 оны 311 тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" байгууллагын дотоод хяналт шалгалт хийх журмын дагуу төлөвлөгөөнд тусгасан ажил бүрээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, төлөвлөгөөнд туссан ажил бүрээр удирдамж төлөвлөгөө боловсруулан ажиллаж, гарсан алдаа зөрчлийн биелэлтийг тооцдог байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Залруулга	1	1274.9	0	0	1	1274.9	1	1274.9	0	0	1	0
Дүн	1	1274.9	0	0	1	1274.9	1	1274.9	0	0	1	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс ажлаас чөлөөлөгдсөн Соёлын төвийн эрхлэгч И.Пүрэвбатад ажилгүй байсан хугацааны цалин 14,694,939 төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас төлсөн	1	14694.9			1	14694.9	1	0 0			0	0
Бараа үйлчилгээний зардлаас 1505900, бусдаар гүйцэтгүүлэх зардлаас 300000 төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн	1	1805.0			1	1805.0						
Бараа үйлчилгээний зардлаас хүндэтгэл үзүүлэх гэх утгатай бэлэг дурсгалын зүйлд 200000 төгрөг зарцуулсан	1	200.0	1	200.0								
Дүн	3	16700.8	1	200	1	16500.8	1					